



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 07 дугаар сарын 08

Дугаар 11/01

Баян-Өндөр сум

Г Хуралдааны дэг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.9 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

- 1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус XI хуралдааны дэгийг хавсралтаар баталсугай.
- 2.Хуралдааны дэгийг мөрдөж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Хуралдаанд оролцогчдод үүрэг болгосугай.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн Ээлжит бус XI хуралдааны 11/01 дугээр тогтооолын хавсралт

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ БУС XI ХУРАЛДААНЫ ДЭГ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн Ээлжит бус XI хуралдаан 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 09:00 цагт аймгийн Нутгийн удирдлагын ордны А.Амарын нэрэмжит их танхимд цахим, танхим хосолсон хэлбэрээр эхэлнэ.

Хурлын хуралдаанд аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын дарга, хэлтэс, алба, агентлагийн удирдлагууд, мэргэжилтнүүд, Ажлын албаны дарга, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд оролцно.

- | | |
|---|--------|
| 1.“Орон нутгийн өмчийн 2022 оны дүнг батлах” тухай | 10 мин |
| 2.“Орон нутгийн өмчтэй хуулийн этгээдийн жишиг цалинг шинэчлэн батлах” тухай | 10 мин |
| 3. Тодотгосон төсөв батлах тухай | 10 мин |
| 4. Тогтоол хүчингүй болгох тухай | 5 мин |
| 5. Аймгийн ИТХ-ын Ээлжит бус XI хуралдааны дэд даргыг нэр дэвшүүлж, санал хураалт явуулж, олонхын саналаар сонгуулна. | |

6. Хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний төслийг танилцуулж, төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах санал байгаа эсэхийг тодруулж, санал хураалт явуулж, олонхын саналаар батлуулна.

7.Хэлэлцэж байгаа асуудлаар гарах шийдвэрийн төслийг эцэслэн боловсруулах Редакцын комиссыг 3 хүртэлх Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллуулна. Редакцын комиссын анхдугаар хурлыг хуралдааны удирдлагын зүгээс хийлгэж, даргыг сонгуулан хуралдаанд мэдэгдэж хурлын материалыг хүлээлгэн өгнө.

8.Хуралдаанд оролцож байгаа Төлөөлөгчдийн ирцийг mIsp.mn программаар бүртгэнэ.

9.Тухайн асуудлаар асуулт асуух, санал хэлэх Төлөөлөгчдийн нэrsийг хуралдааны удирдлагын зүгээс Misp.mn программаар урьдчилан авч дараалалд оруулна. Төлөөлөгчид тус программын санал гэсэн цэс дээр даран өөрийн нэрээ урьдчилан өгнө.

10.Хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар Хурлын Төлөөлөгч хуралдаанд оролцохгүй байх, хуралдааныг орхиж гарахыг хориглоно. Хуралдааныг орхиж гарсан тохиолдолд хуралдаанд оролцож эсрэг санал өгсөнд тооцож санал хураалт явуулна.

11.Тухайн хэлэлцэж байгаа асуудлаар төлөөлөгчдийн асуулт асуух, санал хэлэх хугацаа хүн тус бүрд эхний удаа 3 хүртэл минут, хоёр дахь удаа 2 хүртэл минут байна.

12.Тухайн хэлэлцэж байгаа асуудлаар эцсийн шийдвэр гаргах, асуулт, хариулт, санал, шүүмжлэлийг таслахдаа санал хураалт явуулж олонхын саналаар шийдвэрлэнэ.

13.Хэлэлцэж байгаа асуудлаар цөөнх болсон Төлөөлөгчдийн үндэслэл, саналыг сонсож, дахин нэг удаа санал хураалт явуулж болно.

14. Асуулт тавих, үг хэлэх, санал шүүмжлэл гаргах зөвшөөрлийг хуралдааны удирдлага олгож тогтоосон хугацааг баримтална.

15. Санал, шүүмжлэлийг хуралдааны удирдлагад бичгээр өгч болно. Бичгээр өгсөн санал шүүмжлэлийг хуралдааны удирдлага танилцуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл Редакцын комисст шилжүүлнэ.

16. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Намын бүлэг завсарлага авч болох бөгөөд завсарлагын хугацааг 1 цаг хүртэл байна. Завсарлага авснаас хойш бүлгээс тухайн асуудалд нэгдсэн байр суурь илэрхийлж хуралдаанд оролцно.

17. Намын бүлэгт олгосон завсарлагын хугацаа сунгах шаардлага гарвал хуралдаанаар шийдвэрлэх бөгөөд тогтоосон хугацааг чанд баримтална.

18. Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч нь хуралдаанаар хэлэлцэх асуудал болон шийдвэрийн төслийг боловсруулах, шийдвэр гаргахад оролцох асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй буюу зөрчил үүсэж болзошгүй гэж үзвэл аймгийн ИТХ-ын дарга болон аймгийн ИТХ-ын эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэл гаргана.

19. Хуралдааныг 2 цаг тутам 15 минутын завсарлагатайгаар явуулна.

20. Өдрийн их завсарлага 13.00-14.00 цагийн хооронд байна.

21. Хуралдаан тухайн ажлын өдөр багтахгүй бол үргэлжлүүлэх аль эсвэл дараачийн өдөр шилжүүлэх асуудлыг санал хураалт явуулж олонхын саналаар шийдвэрлэнэ.

22. Хуралдаанд урилгаар оролцогсод зөвлөх эрхтэй оролцох бөгөөд хуралдааны удирдлагаас зөвшөөрөл авч 3 хүртэл минут үг хэлж болно.

23. Хуралдааны мэдээллийг орон нутгийн "Номин" телевиз шууд дамжуулна. Мөн орон нутгийн бусад телевиз, сайт зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан иргэдэд хүргэх боломжоор ханган ажиллана.

24. Хуралдааны үед иргэдтэй харилцах 7035-0494 дугаарын утас ажиллана. Иргэдтэй харилцах утаснаас ирүүлсэн хувь хүний нэр төртэй холбоотойгоос бусад хэлэлцэж буй асуудалтай холбоотой саналыг багцлан хуралдаанд танилцуулж, шаардлагатай бол холбогдох албан тушаалтнаар хариу тайлбар хэлүүлнэ. Харин хэлэлцэж буй асуудалтай хамааралгүй иргэдийн ирүүлсэн хүсэлт, саналыг хуралдаанд танилцуулахгүйгээр шууд холбогдох албан тушаалтанд хүргүүлнэ.

25. Хуралдааны дарга хэлэлцэх асуудлыг хуралдааны дэгийн дагуу амжилттай явагдаж өндөрлөснийг дүгнэж, хуралдааныг хаасныг мэдэгдэнэ.

26. Хуралдааны тэмдэглэлийг ИТХ-ын ажлын албаны хурлын зохион байгуулалт, хууль эрх зүй хариуцсан ахлах мэргэжилтэн хөтөлнө.

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ЭЭЛЖИТ БУС XI ХУРАЛДААН**